



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Булган сум

Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин идэвхжилийн төвшинд байгаатай холбогдуулан ажлын цагийн зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин идэвхжилийн төвшинд байгаатай холбогдуулан 0-5 насны хүүхэдтэй төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл ажлын цагийн хуваарилалт хийж цахимаар ажиллах нөхцөл бололцоог хангах, цалинтай чөлөө олгох асуудлыг зохицуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга, төр, төсвийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

2.Дээрх заасан хугацаанд Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг Боловсролын газар (Б.Мөнхгэрэл), Биеийн тамир, спортын газар (Х.Батхишиг), Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (Г.Алдармөнх)-т тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР